



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

№50 /494/

2023.03.27

Цаг үе, үйл явдал

ЗЭВСГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮД ЧУУЛЛАА



2020 оноос эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, түүний үр дүнгээр зохион байгуулж байгаа "Зэвсэгт хүчний цэргийн зэвсэглэл, техникийн сайжруулалт хийх арга зам-2" сэдэвт онол, практикийн бага хурлыг нээж үг хэлж байгаадаа баяртай байна. Бид шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан зэвсэг, цэргийн техникийг шинэчлэн сайжруулах, шинийг санаачлах, оновчтой санааг дэмжин



ажил хэрэг болгох, бие бүрэлдэхүүний мэдлэг, дадлага, ур чадварыг нэмэгдүүлэх зэрэгт ахиц гаргаж тодорхой амжилт үзүүлж ирснийг та бид мэдэж байгаа. Өнөөдөр Монгол Улсын Зэвсэгт хүчин зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх сэргээн сайжруулах зорилтыг үе шаттайгаар хэрэгжүүлж, инженер, техникийн офицер ахлагч нарын мэдлэг, ур чадварт тулгуурлан дотооддоо тусгай зориулалтын цэргийн техник, нисгэгчгүй нисэх төхөөрөмж, радио электрон хэрэгслийн эхний загварыг амжилттай бүтээсэн билээ. Энэ жил ч гэсэн дээрх арга хэмжээг үргэлжлүүлж туршилт, судалгааны төвүүдээ бэхжүүлэх,



тусгай зориулалтын цэргийн техникийг нэмж үйлдвэрлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Зэвсэгт хүчнээс буудлагын зэвсэглэлийг шинэчлэх ажлын хүрээнд төмөр эд ангиудыг зорж бэлтгэх 5D зоролтын машин, хуванцар эдлэлийг хэвлэгч машинуудыг тус тус хүлээн авч угсран тус машин дээр ажиллах бүрэлдэхүүнийг сургаж эхэлсэн явдалд дэд сайд миний бие баяртай байгаа. Ингэснээр дотооддоо зэвсэглэл, цэргийн техникийн эд ангиудыг зорж бэлтгэх, үйлдвэрлэх ажлын эхлэл тавигдаж, буудлагын



зэвсэг шинэчлэх өргөн боломж нээгдэж байна гэсэн үг. Дээрх арга хэмжээнүүд нь Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх сэргээн сайжруулах, бэлэн байдлыг дээшлүүлэх бодит боломжийг нэмэгдүүлэн инженер, техникийн алба хаагчдын шинийг санаачлах, зохион бүтээх, шинэчлэлд гардан оролцох урам зоригийг нэмж байгаад таатай байна. Иймээс энэхүү бага хурлаас цаашид зэвсэглэлийг шинэчлэх, сэргээн сайжруулах, техник, технологийн ололт дэвшил, инновацыг нэвтрүүлэх, туршилт судалгааны ажлыг эрчимжүүлэх, хүчин чадлыг улам сайжруулахад түлхэц болохуйц шинэлэг санаа, санаачилга, шийдлүүд гарч, ажил хэрэг болно гэдэгт итгэлтэй байна" хэмээсэн юм.

Уг онол практикийн бага хурлаар Цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D) профессор чөлөөнд байгаа хурандаа А.Хүү-Ухна, ЗХЖШ-ын МТГ-ын хэлтсийн дарга Ө.Ганцоож, Ахлах мэргэжилтэн хурандаа Х.Санчирдорж, Хошууч Б.Энхмагнай, АУГ-ын хэлтсийн дарга хурандаа С.Ганбаяр, ХЗЦК-ын хурандаа П.Мөнх-Эрдэнэ, Зэвсэгт хүчний 011



дүгээр ангийн захирагч хурандаа М.Батдорж нар Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн зэвсэглэл, техникийг сайжруулах арга замуудын талаар илтгэл танилцуулж, бие бүрэлдэхүүний дунд нэгдсэн хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Өнөөдөр БХЯ-наа Зэвсэгт хүчний цэргийн зэвсэглэл, техник хариуцсан мэргэжилтнүүдийн төлөөлөл чуулж "Зэвсэгт хүчний цэргийн зэвсэглэл, техникт сайжруулалт хийх арга зам-2" сэдэвт онол практикийн бага хурлыг зохион байгууллаа.

Онол практикийн бага хурлыг нээж Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай хэлсэн үгэндээ "Юуны өмнө Зэвсэгт хүчний чадавхыг илтгэхэд гол үүргийг гүйцэтгэгч засгийн мэргэжлээр овоглосон Та бүхэнд Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 102 жилийн ой, Зэвсгийн алба үүсэж хөгжсөний 102 жилийн ойн мэндийг өргөн дэвшүүлье. ЗХЖШ-аас зэвсэглэл, галт хэрэглэлийн бэлэн байдлын түвшнийг нэмэгдүүлэх, сэргээн сайжруулах зорилгоор



"ЗЭВСГИЙН АЛБАНЫ ӨДӨР"



газрын харьяанд шилжиж, Зэвсгийн хэлтэс болж бие даан байгуулагдсан бөгөөд түүхийн он цагуудад Пуужинт Артиллерийн зэвсэглэлийн 9, 17 дугаар хэлтэс, Пуужинт Артиллерийн зэвсгийн хэлтэс, Цэргийн зэвсэглэлийн хэлтэс, Зэвсгийн хэлтэс, Пуужин Артиллерийн зэвсэглэлийн хэлтэс нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж, Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсэглэл, галт хэрэглэлийн бэлэн байдлыг ханган ажилласаар иржээ.

1921 оны Ардын хувьсгал, 1939 оны Халхын голын байлдаан, Дэлхийн II дайны хүнд жилүүдэд Зэвсгийн хэлтэс нь ЗХУ-аас төрөл бүрийн зэвсэглэл, галт хэрэглэлийг хүлээн авч, Зэвсэгт хүчний зэвсэг, галт хэрэглэлийн бэлэн байдлыг хангаж, өнөөгийн Зэвсгийн албаны суурийг амжилттай тавьсан байдаг юм.

Түүхийн баримтаас сөхөн үзэхэд 1921 оны 11 дүгээр сард ЗХУ-тай хийсэн хэлэлцээрийн дагуу 3000 морьт цэргийг зэвсэглэх зэвсэглэл, галт хэрэглэлийг хүлээн авч, Ардын журамт цэргийн зэвсгийн санг анхлан арвижуулж байжээ.

Батлан хамгаалахын сайдын 2019 оны А/26 дугаар тушаалаар "Зэвсгийн

албаны өдөр"-ийг Зэвсэгт хүчний төрөл мэргэжлийн өдрүүдэд нэмж батлуулсан бөгөөд энэ үеэс эхлэн Зэвсэгт хүчний Жанжин штабын Материал, техникийн газрын Пуужин Артиллерийн зэвсэглэлийн хэлтэс нь Зэвсэгт хүчний зэвсгийн мэргэжилтнүүдийн 3 үеийн уулзалт, эрдэм шинжилгээний бага хурал зэргийг жил бүр санаачлан зохион байгуулж, зэвсгийн мэргэжлийн офицер, ахлагч нарын ур чадвар, мэдлэгийг дээшлүүлж ирсэн юм.

ЗХЖШ-ын Материал, техникийн газрын Пуужин Артиллерийн зэвсэглэлийн хэлтэс нь Монгол Улсын Зэвсэгт хүчний хэмжээнд нэгтгэл, анги, байгууллагуудын зэвсэглэл, галт хэрэглэл, дуран, шилт хэрэгслийн хангалт, төлөвлөлт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулах, хяналт тавих, сэргээн сайжруулалт хийх, Зэвсэгт хүчний зэвсгийн мэргэжлийг бэлтгэх, ур чадварыг нэмэгдүүлэх үүргийг хүлээн ажиллаж, Зэвсэгт хүчний зэвсэглэлийг сайжруулан шинэчлэх, галт хэрэглэлийг дотооддоо үйлдвэрлэх нөхцөл, бололцоог бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

ЗХЖШ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
10	-8

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40	27

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,522	3,526
EUR	3,800	3,830
CNY	517	519
RUB	45.20	45.80
JPY	27	27.20
KRW	2.72	2.75

ЗУРХАЙ



2023.03.27 /ДАВАА ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 6

**ХАВРЫН ДУНД ХӨХӨГЧИН
ТУУЛАЙ САР
ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ХӨХ
БИЧ ӨДӨР**

ҮС ЗАСУУЛБАЛ:
ӨНГӨ ЗҮС САЙЖИРНА
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
06.42-19.14
БАРИЛДЛАГА:
Идэр
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Хурьцахуй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, бурханы үйл, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих цангинавал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой уливал сонсголонтой үг сонсох, тагнай загатнавал гэр арвидах, бие татвал 1-2 хүн ирэх, хөл татвал гомдол аюул болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 683,334,093

Эдгэрсэн

Нийт: 656,273,827

Нас барсан

Нийт: 6,826,925

Монгол Улсын Зэвсэгт хүчинд "Зэвсгийн алба" үүсэн байгуулагдсаны түүхт 102 жилийн ой тохиож байна. Ардын түр Засгийн газрын 1921 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн анхдугаар хурлаар Цэргийн яамны харьяанаас Бүх цэргийн Бэлтгэлийн

Цахим шууданд

ЗЭВСГИЙНХНИЙ ГУРВАН ҮЕИЙН УУЛЗАЛТ БОЛЖ БАЙНА



Монгол Улсын Зэвсэгт хүчинд “Зэвсгийн алба” үүсэн байгуулагдсаны түүхт 102 жилийн ойг тохиолдуулан зэвсгийн мэргэжилтнүүдийн гурван үеийн уулзалт 3 дугаар сарын 24-ний энэ өдөр зохион байгуулагдаж байна.

Уулзалтын арга хэмжээний эхэнд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалд зочилж, орон нутагт шилжин байрласнаас хойшхи ололт амжилтыг сонсож, бие бүрэлдэхүүний алба хаах орчин нөхцөлийг хэрхэн дээшлүүлж буйтай танилцсан юм. Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга, хурандаа Ц.Буяндэлгэр “Цэргийн

мэргэжлийн дотор хамгийн эрхэм бөгөөд хариуцлагатай ажил, албыг эзэмшсэн үе үеийн зэвсгийнхний цагийн түүхэнд бүтээсэн гавьяат үйлсээр бахархах, өсвөр, залуу үеийн цэрэг-эх оронч сэтгэлгээг нь бадраах, эх орноо гэсэн хүсэл эрмэлзэл, хайрлан хамгаалах үзэл бодлоор цэнэглэхэд үлгэр дуурайлал үзүүлэх нь энэ өдрийн гол ач холбогдол юм.

Ардын журамт цэрэг байгуулагдсанаар Монгол цэргийн шинэ үеийн түүхийн хуудсыг нээж, морьт цэргээс мото механикжуулсан цэрэг, улмаар мотобуудлагын цэрэг болон хөгжих их үйлсийн манлайд

явсан зэвсгийнхний ахмад дайчид, тэдний нэр хүндийг өндөрт өргөж яваа эрхэм генерал, офицер, ахлагч Та бүхэндээ дахин баярын мэндийг дэвшүүлж, албанд нь өндөр амжилт, амьдралд нь хамгийн сайхан бүхнийг хүсэн ерөөе” гээд Хуурай замын цэргийнхний сүүлийн үеийн ажил албаны амжилтаас товч танилцууллаа.

Үе үеийн зэвсгийнхний уулзалтаар дурсамж яриа өрнүүлэх, шагнал гардуулах, зарлагдсан уралдааны дүнг танилцуулах зэрэг баярын цөөнгүй арга хэмжээ багтжээ.



ОНОЛ, ПРАКТИКИЙН ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



ҮБХИС-ийн Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв БХЯ, ЗХЖШ-тай хамтран “Зэвсэгт хүчний ахлагч бэлтгэх сургалтын байгууллага-өнгөрсөн, одоо, ирээдүй” сэдэвт эрдэм шинжилгээний онол, практикийн хурлыг зохион байгууллаа.

Уг эрдэм шинжилгээний хурлыг нээж ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал доктор (Sc.D), профессор хурандаа Б.Өлзийхуяг хэлсэн үгэндээ өнөөдрийн эрдэм шинжилгээний хурлын зорилго нь ахлагч бэлтгэх сургалтын

байгууллагын үүрэг оролцоо, одоогийн үйл ажиллагааны түвшинд үнэлгээ хийж цаашдын зорилго, зорилтыг хамтран тодорхойлоход оршиж буйг онцлоод мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн ахлагч бол Мэргэжлийн цэрэгт суурилсан цомхон, чадварлаг Зэвсэгт хүчинтэй байх гэсэн Монгол Улсын Засгийн газрын бодлогын гол үндэс суурь болохыг илэрхийлсэн юм.

Эрдэм шинжилгээний хурлаар “Монгол Улсын Зэвсэгт хүчний ахлагчийн албаны хөгжилд сургалтын байгууллагын үүрэг оролцоо”, “Ахлагч бэлтгэх сургалтын байгууллагын

түүхэн замнал, хөгжил”, “Ахлагчийн сургуулийн хөгжил дэвшилд үе үеийн ажилтан, алба хаагчдын оруулсан хувь нэмэр үүрэг оролцоо”, “Багшийн хөгжил, хариуцлага сургалтын чанарт нөлөөлөх нь”, “Төгсгөчдийн сэтгэл ханамжийн байдал” зэрэг сэдвийн хүрээнд БХЭШХ-ийн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга хурандаа Т.Соронзонболд, Эрдэм шинжилгээний ахлах ажилтан дэд хурандаа Н.Хүдэрбат, ЗХЖШ-ын тэргүүн ахлагч Н.Баасан тэргүүтэй хүмүүс илтгэл хэлэлцүүлж төгсгөлд нь бие бүрэлдэхүүний дунд санал асуулга явуулсан юм.



“ЗЭВСЭГТ ХҮЧИН-БИДНИЙ БАХАРХАЛ” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАА



Нийслэлийн Сонгино хайрхан дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Сонгино хайрхан дүүргийн цэргийн штаб, Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн хамтарсан төлөвлөгөөний дагуу “Зэвсэгт хүчин бидний бахархал” арга хэмжээ 2023.03.23-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, цэргийн албыг сурталчлан таниулах зорилгын хүрээнд Сонгино Хайрхан дүүргийн 4 ерөнхий боловсролын дөрвөн сургуулийн 100 гаруй ахлах ангийн сурагчид оролцлоо. Уг арга хэмжээнд Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн захирагч хурандаа Ч.Эрдэнэболд, НЗДТГ-ын Цэргийн штабын Батлан хамгаалах хууль тогтоомж, хяналт шинжилгээ хариуцсан ахлах офицер

хурандаа М.Мөнгөнтулга, Сонгино хайрхан дүүргийн засаг даргын тамгын газрын цэргийн штабын дарга дэд хурандаа Б.Нямгэрэл тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо.

Энэхүү үйл ажиллагаанд анги, байгууллагын үйл ажиллагаатай танилцах, цэргийн байр, туршилт судлагааны төв болон хээрийн холбооны зангилгааг дэлгэн байгуулж, орчин үеийн холбоо мэдээллийн систем, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг үзүүлж сонирхууллаа. Мөн ангийн танилцуулга, урлагийн хэсэгчилсэн тоглолт, жагсаал болон гардан тулааны үзүүлэх тоглолтыг сонирхуулж хугацаат цэргийн алба хаагчидтай үдийн зоог барих үйл ажиллагааг зохион байгуулсан юм.

Дэслэгч Н.УУГАНЦЭЦЭГ



ЧИНГИС ХААНЫ МУЗЕЙГЭЭР АЯЛЛАА



Ажилтан, алба хаагчдын түүх, соёлын мэдлэгийг дээшлүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилгын хүрээнд орчин Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-

ийг тохиолдуулан Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн бүрэлдэхүүн Чингис хаан үндэсний музейгээр гэр бүлийн хамт зочиллоо.

Ахлах дэслэгч С.СУВДАНЧИМЭГ

